



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ
ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Э.ПҮРЭВЖАВ ТАНАА

2017.02.23 № 3/318
танай _____-ны № _____-Т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kherag\Yawsan_Bichig\2017\02\23\AGZ4.docx



ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ”
УТУГ-ЫН 2016 САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46, Бага тойруу 6

Web: www.audit.gov.mn
ҮАГ Санхүүгийн аудитын газрын
захирал: Ц.Наранчимэг

Утас: 261663
И-мэйл: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл:
Sambuunyamyia@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Ихмонгол хөлөг Аудит” ХХК
Утас: 70001778
Web: www.imkaudit.mn

Захирал: С.Тунгалаг
Утас: 99061771
И-мэйл: tungalag.s@imkaudit.mn

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Д.Пүрэвжаргал
И-мэйл: purevjargal.d@imkaudit.mn

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлангууд

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТЫН КОД:
ҮАГ-САГ/2017/17/-СТА-УТУГ

Агуулга

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:	3
Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:	4
Гурав. Байгууллагын зорилго үйл ажиллагаа:	5
Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн:	5
Тав. Материаллаг байдал:	7
Зургаа. Дотоод хяналт	7
Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	7
Найм. Шилэн дансны мэдээлэл	8
Ес. Олж тогтоосон эрсдлүүд, түүний үр дагавар	8
Арван. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар	9
Арван нэг. Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	10
Арван хоёр. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	10
Арван гурав. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	12
Арван дөрөв. Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
Арван тав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	13
Арван зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	13
Арван долоо: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:	13
Арван найм: Зөвлөмж	13
Арван ес. Зөрчилгүй дүгнэлт	13

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дах заалтуудыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд “Ихмонгол хөлөг Аудит” ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 9.1-д заасан төсвийн цаглабарт заасан хугацаанаас 2 хоногоор хоцроож, 1 дүгээр сарын 27-нд “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д ирүүлсэн.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25 -наас 2 дугаар сарын 10 -ны хооронд хийхээр төлөвлөн “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 28-наас 2017 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-нь дараахь хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд:

- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Усны тухай хууль
- Өрсөлдөөний тухай хууль
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
- Ариун цэврийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоол
- Засгийн газрын 2012 оны 183 дугаар тогтоолууд зэрэг байна.

Тайлант хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго үйл ажиллагаа

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын үйл ажиллагаа нь “Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”, Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулагдах бөгөөд тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй хэрэглэгчийн төлөөлөл, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бие даасан, хараат бус хамтын удирдлагын байгууллага юм.

Зохицуулах зөвлөлийн эрхэм зорилго нь:

Монгол Улсад ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг үр ашигтай гүйцэтгэх нөхцөл бололцоог бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн чанар, стандарт бүхий найдвартай, тэгш, хүртээмжтэй үйлчилгээг баталгаажуулах оновчтой зохицуулалтыг хийхэд оршино.

Үндсэн чиг үүрэг нь: Цэвэр бохир усны үйлчилгээний үнэ тариф тогтоох аргачлал, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх, хот суурины ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянахад чиглэгдэж байна.

Дээрх зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу Зохицуулах зөвлөлийн дарга Ч.Пүрэвжав төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тус зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтанд тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 48 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын даргын 2014 оны 12 дугаар сарын 29-А/58 дугаар тушаалаар батлуулан мөрдөж ажилласан байна.

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах зорилгоор үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Зохицуулах зөвлөл нь улсын бүртгэлд, төсөвт аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар бүртгэгдсэн, санхүүгийн тайланг төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн заавар аргачлалаар бэлтгэж ирсэн байна.

Уг баримт бичигт НББОУС-ыг мөрдөхөөр заасан нь НББ-ийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 4.4-д "4.1.3-т заасан стандартыг төсвийн тухай хуулийн /6/ 4.1. 34-т заасан байгууллага мөрдөнө", Төсвийн тухай хуулийн 4.1.34-д “төсвийн байгууллага” гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг,” гэж заасантай нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт нь санхүүгийн програм хангамжид бүртгэгдсэн дансны жагсаалттай нийцээгүй, шинэчлэн батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай, ТБОНӨ-

ийн тухай хуулиуд, түүнтэй нийцүүлэн гаргасан тушаал шийдвэрүүдийн холбогдох өөрчлөлтүүдийг бодлогын баримт бичигт найруулж тусгаагүй байна.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “хэвийн” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “ACOLOUS-3.0” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тав. Материаллаг байдал:

ТАБ-СТА-А-4 маягтыг ашиглан материаллаг байдлын суурийг 2016 оны Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн зарлагын 1 хувиар сонгов.

Материаллагын байдлыг тогтоохдоо нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн бага байгаа тул нийт мөнгөн зарлагын 1 хувиар авч үзэх нь чанарын хувьд тохирно гэж үзлээ.

“Хот, суурин ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн зарлага 636.2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 6.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Зургаа. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийн нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад сул байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Засгийн газрын 2016 оны 275 дугаар тогтоолоор ХСУЧАТАҮЗЗ-ийн 2016 оны үйл ажиллагааны төсвийг 612.1 сая төгрөгөөр баталсан байна.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн 2016 оны 39 дүгээр тогтоолоор Ус хангамж, ариутгах татуургын зохицуулалтын үйлчилгээний хураамжийн орлогыг 107 аж ахуйн нэгж байгууллагаас 612.1 сая төгрөгөөр тогтоосон байна.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-нь 2016 онд нийт 95 байгууллагаас 572.6 сая төгрөгийг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 93.5 хувиар биелүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 560.3 сая төгрөгөөр тайлагнагдаж зардлын гүйцэтгэл 91.5 хувьтай байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас төлсөн зохицуулах үйлчилгээний хураамжийн орлогыг Худалдаа хөгжлийн банкны 460006270 тоот харилцах дансаар дамжуулан төвлөрүүлж үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулахад нийт зардлын дүнгээр 33.2 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

“ХСУЧАТАҮЗЗ” нь Шилэн дансны тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны “Журам батлах тухай” 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор өөрийн wsrs.gov.mn веб сайтад Шилэн данс цэсийг байршуулж дараахь мэдээллийг оруулсан байна. Үүнд:

- Зохицуулах зөвлөлийн 2016 оны 2, 3-р улирлын санхүүгийн тайлан
- 2016 оны төсвийн орлого, зарлагын мэдээ
- 2016 оны 9, 11, 12 сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2016 оны 10, 11, 12 –р саруудын 5.0 сая төгрөгөөс дээшх мөнгөн гүйлгээний тайлан зэрэг мэдээллийг байршуулсан байна.

Ес. Олж тогтоосон эрсдлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу уламжлалт болон хяналтын 55 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитын явцад дараахь гол эрслүүдийг олж тогтоов.

Үр дагавар: Авлага, өглөгийн үлдэгдлийг оны эхнээс нэмэгдүүлсэн, тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулаагүй, орлогыг өр төлбөрөөр бүртгэсэн, орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс орлого, авлагыг дутуу тайлагнасан, тайлант оны орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, зохицуулалт үйлчилгээний хураамж төлөгч байгууллагуудын гадаад арга хэмжээний зардлыг өөрийн байгууллагын дансад төвлөрүүлэн зарцуулахдаа, Зохицуулах зөвлөлийн 3 ажилтны гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зарим стандартын заалтууд, дотоодод мөрдөх журмуудыг тусгаагүй зэрэг зөрчлүүд байна.

Арав. Гол онцлог гүйлгээний талаарх тайлбар

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа үйлчилгээний орлого, зардал, авлага, өр төлбөр зэрэг дансад ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа./ТАБ-СТА-В-3/

Тайлант жилд гарсан онцлог гүйлгээг дурдвал:

2016 онд “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны төсөвт гадаад албан томилолтын зардлыг баталж өгөөгүй байна. Тус байгууллага нь зохицуулалт үйлчилгээний хөлс төлдөг 14 байгууллагаас гадаад арга хэмжээнд ажилтнуудыг нь хамруулах зорилгоор 90.7 сая төгрөгийг өөрийн байгууллагын харилцах дансанд төвлөрүүлж, өглөгөөр бүртгэн батлагдсан зардлын төсвийн дүнгээр өглөгийг хааж бүртгэсэн байна.

Зохицуулалт үйлчилгээний хураамж төлөгч байгууллагуудаас шилжүүлсэн гадаад арга хэмжээний дээрх зардлаас “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн Тусгай зөвшөөрлийн албаны дарга П.Долгорсүрэн, Үнэ тарифын албаны дарга Ж.Гэрэлчулуун, ерөнхий нягтлан бодогч Ч.Саранхүү нарын 3 хүний 16.9 сая төгрөгийн гадаад арга хэмжээний зардлыг санхүүжүүлсэн байна.

UNICEF хүүхдийн сангаас “Усны тэгш, хүртээмжтэй тариф” WASH 511 төслийн хэрэгжүүлэхэд 136.1 сая төгрөгийн санхүүжүүлтийн гүйлгээг Төрийн банк дахь

108801378047 дугаар нэмэлт санхүүжилтийн дансаар хийж, 59.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Арван нэг. Завсрын аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” УТҮГ-ын 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 11 дүгээр сарын 26-ны өдөр хүртэлх хугацаанд завсрын аудит хийж, 1,346.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж, 1,329.1 сая төгрөгийн алдааг залруулж 10 асуудлаар зөвлөмж бэлтгэн хүргүүлж 7 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Арван хоёр. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Зохицуулах зөвлөлийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил болон удирдлагын анхааралд хандуулах гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.Үүнд:

1. Нэр данс зөрүүтэй буцаж орсон 5.4 сая төгрөгийн гүйлгээг нэмэлт санхүүжилтийн дансны журналд бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд тусган, залруулж тайлагнав.

2. Худалдаа хөгжлийн банкинд байрлах 411024204 тоот жижиг мөнгөн сангийн данснаас гадна байгууллагын касс оны эхэнд 255.7 мянган төгрөгийн, оны эцэст 174.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эцэст кассын үлдэгдлийг тоолж тооцоо бодоогүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудит хийх хугацаанд тооцоог бодож баталгаажуулсан.

3. Худалдаа хөгжлийн банкинд байрлах 411024204 тоот дансны эцсийн үлдэгдэл 11.5

мянган төгрөгийг тохируулах бичилтээр байгууллагын касс гэж хаалтын бичилт хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Банкан дахь харилцах дансдын үлдэгдлийг нягтлан бодох бүртгэл тайланд үнэн зөвөөр тусгаж байх зөвлөмж өгсөн.

4. Зохицуулалт үйлчилгээний хөлс төлөгч 12 байгууллагын 94.0 сая төгрөгийн авлагын, 24.6 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүнээс: 2 жилээс дээш хугацаагаар он дамжсан 2 байгууллагын 66.6 сая төгрөгийн авлага нь нийт авлагын 70.8 хувийг эзэлж байна. Нийт авлагын 54.5 хувь буюу 4 байгууллагын 51.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Он дамжин төлөгдөхгүй байгаа авлагыг барагдуулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах арга хэмжээг авах албан шаардлага өгсөн.

5. 2016 оны 7-12 сарын байдлаар бараа материалын тайланд 5.4 сая төгрөгийн 414 ажил гүйлгээний орлогын болон зарлагын баримт нь тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-дугаар зүйлийн 13.5.-д заасан "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасныг дагаж мөрдөх зөвлөмж өгсөн.

6. 18 төрлийн 800.0 мянган төгрөгийн номын ашиглах хугацааг санхүүгийн програмд бүртгэхдээ -1 гэж буруу бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн програмд тохируулга хийж залруулав.

7. "Усны тэгш, хүртээмжтэй тариф" wash511 төслийн усны үйлчилгээний тариф тооцоолох загвар боловсруулах "Цэвэр бохир усны үйлчилгээний өртөг тариф тооцоолох" програм хангамжийн зөвлөх үйлчилгээнд олгосон 10.8 сая төгрөгийн дүнгээр програм хангамжийн өртгийг капиталжуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд биет бус хөрөнгийн үнийг 10.8 сая төгрөгөөр капиталжуулан залруулав.

8. Unicef хүүхдийн сангаас санхүүжүүлсэн төслийн 2 дугаар шатны санхүүжилтийн орлогыг тус байгууллагад өгөх өглөгөөр бүртгэж тайлагнаснаас санхүүгийн байдлын тайлангийн үлдэгдлийн дүн, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд 58.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн болон санхүүгийн тайлангийн тодруулгуудад залруулга

хийж, орлогоор тайлагнав.

9. Зохицуулалт үйлчилгээний хураамж төлөгч нийт 107 байгууллагуудаас 612.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс 572.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 39.5 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Тайлант онд батлагдсан хуваарийн дагуу Зохицуулалт үйлчилгээний хураамж төлөгч байгууллагуудаас хураамхийг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага өгсөн.

10. Түрээсийн төлбөрт төлөхөөр тооцсон нийт 79.3 сая төгрөгөөс 51.5 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансанд бичилт хийхгүйгээр шууд зардлаар бүртгэснээс санхүүгийн тайлангийн тодруулгад түрээсийн төлбөр 27.8 сая төгрөгөөр тайлагнасан, програм хангамжийн тохиргоог алдаатай хийснээс мөнгөн гүйлгээний тайлангийн цэвэр мөнгөн гүйгээний дүн 2.4 сая төгрөгөөр, мөнгөн суурьт шалгах балансын гүйлгээ 10.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнагдсан.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд залруулга хийж 64.8 сая төгрөгийг залруулан бүртгэж тайлагнав.

11. Зохицуулалт үйлчилгээний хураамж төлөгч байгууллагуудаас шилжүүлсэн гадаад арга хэмжээний зардлаас “ХСУХАТАУ33”-ийн Тусгай зөвшөөрлийн албаны дарга П.Долгорсүрэн, Үнэ тарифын албаны дарга Ж.Гэрэлчулуун, ерөнхий нягтлан бодогч Ч.Саранхүү нарын 3 хүний 16.8 сая төгрөгийн гадаад арга хэмжээний зардлыг санхүүжүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зохицуулалт үйлчилгээний хураамж төлөгч байгууллагуудын зардлаас зарим ажилтны гадаад арга хэмжээний зардлыг санхүүжүүлж ирсэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Арван гурав. Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

16.8 сая төгрөгийн гадаад арга хэмжээний зардлыг санхүүжүүлсэн, 612.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээс 572.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 39.5 сая төгрөгөөр тасалдуулсан, авлагын 54.5 хувь буюу 4 байгууллагын 51.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүдэд албан шаардлага өгөв. .

Арван дөрөв. Анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Зохицуулах зөвлөл нь төсөвт аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар улсын бүртгэлд бүртгэгдсэн, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн заавар аргачлалаар санхүүгийн тайлангаа бэлтгэж ирсэн боловч байгууллагынхаа НББББ-ийн баримт бичигт НББОУС-ыг мөрдөхөөр заасан байна.

Арван тав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Орлого бүрдүүлэлт, авлага, өр төлбөрийн барагдуулалтыг дараагийн аудитаар авч үзэх, мөн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон төсвийн бүлэг дотор хэтрүүлэн зарцуулсан талаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

Арван зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 1,346.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,329.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан.

2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 305.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 193.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 5.4 сая төгрөгийн зөвлөмж, 107.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгөв.

Арван долоо: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2015 оны санхүүгийн тайланд хийх аудитыг Үндэсний Аудитын Газрын САГ-ын аудитор Ж.Болормаа гүйцэтгэж 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Арван найм: Зөвлөмж

Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгч менежментийн захидлыг хавсаргав.

Арван ес. Зөрчилгүй дүгнэлт

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, зохицуулалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлангууд болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан 7 хуудас хавсаргав.



ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46, Бага тойруу 6

Web: www.audit.gov.mn

ҮАГ Санхүүгийн аудитын газрын
захирал: Ц.Наранчимэг

Утас: 261663

И-мэйл: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 260512

И-мэйл:

Sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Д.Ганбилэг

Утас: 261885

Имэйл: ganbilegd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК

Утас: 70001778

Web: www.imkaudit.mn

Захирал: С.Тунгалаг

Утас: 99061771

И-мэйл: tungalag.s@imkaudit.mn

Аудитын багийн ахлагч:

Аудитор: Д.Пүрэвжаргал

И-мэйл: purevjargal.d@imkaudit.mn

**ХОТ, СУУРИНЫ УС
ХАНГАМЖ, АРИУТГАХТАТУУРГЫН
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1:

Нягтлан бодох бүртгэлийн талаар

Асуудал 2:

Мөнгөн хөрөнгийн талаар

Асуудал 3:

Бараа материалын талаар

2017 оны 2 дугаар сарын 10

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Хот,Суурины Ус хангамж, Ариутгах Татуургын Ашиглалт Үйлчилгээг Зохицуулах Зөвлөл”-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Хот,Суурины Ус хангамж, Ариутгах Татуургын Ашиглалт Үйлчилгээг Зохицуулах Зөвлөл”-ийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Нягтлан бодох бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

1. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт нь санхүүгийн программ хангамжид бүртгэгдсэн дансны жагсаалттай нийцэхгүй байна.

2. Шинэчлэгдэн батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан тушаал шийдврийн холбогдох өөрчлөлтүүдийг бодлогын баримт шинэчлэн найруулж тусгаагүй байна.

3. Тус байгууллага нь төсөвт аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар улсын бүртгэлд бүртгэгдсэн, төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн заавар аргачлалаар санхүүгийн тайлангаа бэлтгэж ирсэн боловч байгууллагынхаа НББББ-ийн баримт бичигт НББОУС-ыг мөрдөхөөр заасан нь НББ-ийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 4.4-д "4.1.3-т заасан стандартыг төсвийн тухай хуулийн /6/ 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, их бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журам, холбогдох стандартыг хэрэгжүүлэхгүй байх./ЭБ,ҮЗ/

Зөвлөмж

1. Сангийн Яамны НББББГазар, Сангийн Сайдын дэргэдэх стандартын зөвлөлд хандан холбогдох стандартуудын дагуу хуульд нийцүүлэн байгууллагын НБББББ-т холбогдох өөрчлөлтүүдийг оруулан мөрдөх.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Мөнгөн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	---------------------------

Ажиглалт

1. Худалдаа хөгжлийн банкинд байрлах 411024204 тоот жижиг мөнгөн сангийн данснаас гадна байгууллагын кассст оны эхэнд 255,777.00 төгрөгийн, оны эцэст 174,126.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Оны эцэст кассын үлдэгдлийг тоолж тооцоо бодоогүй байна.
2. Худалдаа хөгжлийн банкинд байрлах 411024204 тоот дансны эцсийн үлдэгдэл 11,467.57 төгрөгийг тохируулах бичилтээр байгууллагын кассад гэж хаалтын бичилт хийсэн байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомж, заавар журам, холбогдох стандартыг хэрэгжүүлэхгүй байх/ТИ,ҮЗ/

.

Зөвлөмж

1. Сар бүрийн эцэст кассын үлдэгдлийг тоолж тооцоо бодож байх.
2. Банкан дахь харилцах дансдын үлдэгдлийг нягтлан бодох бүртгэл тайланд үнэн зөвөөр тусгаж байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

Асуудал 3: Бараа материалын талаар талаар	Тэргүүлэх ач холбогдол № 1
---	----------------------------

Ажиглалт

2016 оны 7-12 сарын байдлаар бараа материалын тайланд дахь 5,375,441.00 төгрөгийн 414 ажил гүйлгээний орлогын болон зарлагын баримт нь тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажгаагүй байна.

Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.-д заасан "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэж заасныг дагаж мөрдөх

Эрсдэлүүд

Санхүү бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар зөрчигдөх / ҮЗ/

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

**“ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	180,121,489.40	299,659,552.26
МӨНГӨН ХӨРӨНГӨ	124,750,076.76	204,178,924.63
Кассанд байгаа бэлэн мөнгө	300,633.66	185,593.57
Төгрөг\ ЖМС	300,633.66	185,593.57
Төрийн сангийн харилцах	124,449,443.10	144,425,975.24
Нэмэлт санхүүжилтийн харилцах		59,567,355.82
АВЛАГА	54,495,826.64	94,016,763.22
Бусад авлага	54,495,826.64	94,016,763.22
Байгууллагаас авах авлага	54,495,826.64	94,016,763.22
УРЬДЧИЛГАА	-	-
БАРАА МАТЕРИАЛ	875,586.00	1,463,864.41
Түүхий эд материал	319,000.00	817,850.00
Тусгай зориулалттай материал	319,000.00	817,850.00
Хангамжийн материал	556,586.00	646,014.41
Бичиг хэргийн материал	487,660.00	529,913.00
Аж ахуйн материал	68,926.00	18,582.00
Түлш, шатах тослох материал		80,550.01
Бусад хангамжийн материал		16,969.40
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	180,138,458.80	299,659,552.26
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	101,677,062.19	111,039,574.17
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	101,677,062.19	111,039,574.17
Биет хөрөнгө	96,455,048.47	91,093,352.17
Авто-тээврийн хэрэгсэл	59,257,500.08	51,717,500.12
Авто-тээврийн хэрэгсэл - Анхны өртөг	75,400,000.00	75,400,000.00
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(16,142,499.92)	(23,682,499.88)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,139,836.98	10,819,761.57
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	39,294,359.00	47,583,849.00
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(28,154,522.02)	(36,764,087.43)
Тавилга, аж ахуйн эд хогшил	25,219,398.18	26,600,167.29
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	36,698,100.00	42,533,650.00
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(11,478,701.82)	(15,933,482.71)
Бусад үндсэн хөрөнгө	838,313.23	1,955,923.19
Номын фонд	52,540.00	1,202,750.00
Бусад үндсэн хөрөнгө	869,990.00	869,990.00
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(84,216.77)	(116,816.81)
Биет бус хөрөнгө	5,222,013.72	19,946,222.00
Програм хангамж	5,222,013.72	19,946,222.00
Програм хангамж - Анхны өртөг	5,880,000.00	22,449,000.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(657,986.28)	(2,502,778.00)

ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	101,677,062.19	111,039,574.17
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	281,815,520.99	410,699,126.43
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,510,897.60	24,573,188.67
Өглөг	10,510,897.60	24,573,188.67
Ажилчидтай холбогдсон тооцоо	-	13,985,768.67
Цалингийн өглөг		12,703,117.50
НДШ-ийн өглөг	-	1,282,651.17
Бусад өглөг	10,510,897.60	10,587,420.00
Байгууллагад төлөх өглөг	10,510,897.60	10,587,420.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	10,510,897.60	24,573,188.67
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	10,510,897.60	24,573,188.67
Засгийн газрын сан	-	-
Засгийн газрын оруулсан капитал ЗГСсан орон нутгийн		20,000.00
Хуримтлагдсан үр дүн	271,304,623.39	386,105,937.76
Өмнөх үеийн үр дүн	271,304,623.39	271,284,623.39
Тайлант үеийн үр дүн		114,821,314.37
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	271,304,623.39	386,125,937.76
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	281,815,520.99	410,699,126.43

**“ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	548,964,077.49	755,173,663.86
Нийтлэг татварын бус орлого	2,828,630.93	3,614,396.86
Хүүгийн орлого	2,828,630.93	3,614,396.86
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	546,135,446.56	618,312,180.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	537,146,689.67	612,078,680.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	283,859.89	6,233,500.00
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	8,704,897.00	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	133,247,087.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	133,247,087.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс	-	133,247,087.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	548,964,077.49	755,173,663.86
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	305,524,179.57	372,550,938.78
Үндсэн болон нэмэгдэл цалин	275,880,388.39	334,265,669.75
Үндсэн цалин	231,191,089.93	255,282,829.75
Нэмэгдэл цалин	7,632,053.50	9,600,000.00
Унаа, болон бусад нөхөн олговор	20,344,600.75	20,562,000.00
Үр дүнгийн урамшуулал	16,712,644.21	22,420,840.00
Гэрээт ажилчдын цалин	-	26,400,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	29,643,791.18	38,285,269.03
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	21,085,695.18	27,679,629.58
Тэтгэврийн даатгалын шимтгэл	18,837,913.18	24,840,693.50
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,247,782.00	2,838,936.08
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,809,727.00	3,487,898.91
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	522,579.00	647,067.40
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,225,790.00	6,470,673.14
УРСГАЛ ЗАРДАЛ	177,234,844.55	233,892,092.31
Бараа үйлчилгээний урсгал зардал	177,234,844.55	233,892,092.31
Бусад бараа үйлчилгээний зардал	177,234,844.55	233,892,092.31
Бичиг хэргийн зардал	6,599,359.00	6,529,579.70
Тээвэр, шатахуун	5,346,900.00	7,974,949.99
Шуудан, харилцаа холбоо	8,987,957.09	5,952,111.24
Дотоод албан томилолт	5,431,090.00	13,009,844.00
Гадаад албан томилолт	17,688,312.00	1,828,550.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	-	2,691,600.00
Багаж хэрэгсэл худалдан авах	2,784,788.00	-
Тавилга	90,000.00	-

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,419,293.00	2,538,048.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	2,575,763.51	-
Урсгал засвар	4,467,627.00	6,970,670.00
Хичээл сургалт, үйлдвэрлэл дадлагын зардал	4,125,227.00	11,515,062.60
Нийгмийн даатгалын алданги	-	1,366,985.00
Бусад зардал	7,803,990.00	1,846,107.90
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,771,953.25	22,481,738.02
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,960,350.00	51,982,844.90
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	587,400.00	2,000,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	1,791,825.30	2,612,790.96
Тээврийн хэрэгслийн татвар	220,500.00	135,150.00
Тээврийн хэрэгслийн оншилгоо	104,500.00	40,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээний х	30,964,800.00	13,131,060.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээ	324,719.40	-
Мэдээлэлийн маягтын зардал	801,000.00	-
Байрны түрээс	51,387,490.00	79,285,000.00
Татаас	3,895,000.00	-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,895,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,350,207.60	33,964,296.00
Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,577,257.60	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,577,257.60	-
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	3,772,950.00	33,964,296.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж , урамшуулал	2,972,950.00	33,964,296.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулал	800,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	493,004,231.72	640,407,327.09
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	55,959,845.77	114,766,336.77
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	54,977.60
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	55,959,845.77	114,821,314.37

**“ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрхи**

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Өмнөх он	Тайлант он
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	133,247,087.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	-	133,247,087.00
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	-	133,247,087.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс	-	133,247,087.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	494,379,214.94	582,405,640.28
Хүүгийн орлого	2,828,630.93	3,614,396.86
Бараа, үйлчилгээний борлуулалт	491,550,584.01	578,791,243.42
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	491,550,584.01	578,791,243.42
Үндсэн үйл ажиллагааны орлого	482,650,863.03	572,557,743.42
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	194,823.98	6,233,500.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	8,704,897.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	494,379,214.94	715,652,727.28
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	466,579,416.28	636,223,879.41
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	308,027,283.49	358,762,897.41
Үндсэн болон нэмэгдэл цалин	277,571,501.00	321,776,558.40
Үндсэн цалин	232,882,182.34	251,990,643.40
Нэмэгдэл цалин	7,632,053.50	9,600,000.00
Үр дүнгийн урамшуулал	16,712,664.41	13,223,915.00
Гэрээт ажилчдын цалин	-	26,400,000.00
Унаа, хоолны хөнгөлөлт	20,344,600.75	20,562,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	30,455,782.49	36,986,339.01
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	21,895,331.69	30,698,044.93
Тэтгэврийн даатгалын шимтгэл	19,755,219.02	23,951,475.40
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,140,112.67	2,737,311.14
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,029,935.24	3,396,678.97
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	499,548.73	612,579.42
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,030,966.83	6,288,294.08
УРСГАЛ ЗАРДАЛ	154,779,182.79	243,496,686.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	154,779,182.79	243,496,686.00
Бусад бараа үйлчилгээний зардал	154,779,182.79	243,496,686.00
Бичиг хэргийн зардал	3,779,910.00	9,360,907.70
Тээвэр, шатахуун	5,910,000.00	7,854,000.00
Шуудан, харилцаа холбоо	9,167,857.09	5,909,111.24
Дотоод албан томилолт	4,794,000.00	13,138,944.00
Гадаад албан томилолт	17,796,384.00	1,699,450.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах		1,666,600.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	4,024,694.00	12,597,062.60
Багаж хэрэгсэл худалдан авах	4,868,994.00	-

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1,035,646.00	2,361,289.00
Тавилга		14,462,740.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,895,000.00	-
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,452,280.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний хөлс	1,960,350.00	64,994,617.60
Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс /гадаад/	587,400.00	2,000,000.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	324,719.40	43,000.00
Нийгмийн даатгалын алданги		1,366,985.00
Эд хөрөнгийн даатгал	1,791,825.30	2,612,790.96
тээврийн хэрэгслэлийн даатгал	220,500.00	135,150.00
Тээврийн хэрэгслэлийн оношлогоо	104,500.00	40,000.00
Урсгал засвар	4,524,227.00	6,970,670.00
зочин төлөөлөгч зардал	2,571,079.00	-
Бусад зардал	7,953,447.00	1,867,307.90
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
Байрны түрээс	51,387,490.00	79,285,000.00
Улсын мэдээлэл технологийн үйлчилгээ	26,628,880.00	15,131,060.00
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	3,772,950.00	33,964,296.00
Нэг удаагийн тэтгэмж	800,000.00	-
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	2,972,950.00	33,964,296.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	466,579,416.28	636,223,879.41
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	27,799,798.66	79,428,847.87
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	27,799,798.66	79,428,847.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	124,750,076.76
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,799,798.66	204,178,924.63

**“ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	271,304,623.39	271,304,623.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,000.00	-	(20,000.00)	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	271,284,623.39	271,284,623.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	114,821,314.37	114,821,314.37
2016 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл	20,000.00	-	386,105,937.76	386,125,937.76

**“ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ” УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

Эдийн засгийн ангилал	Батлагдсан төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	124,750,076.76		
I.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	612,078,680.00	558,929,751.37	(53,148,928.63)	91.3%
II.НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	612,078,680.00	558,929,751.37	(53,148,928.63)	91.3%
III. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	612,078,680.00	558,929,751.37	(53,148,928.63)	91.3%
Бараа ажил үйлчилгээний зардал	612,078,680.00	558,929,751.37	(53,148,928.63)	91.3%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	371,538,000.00	321,380,558.40	(50,157,441.60)	86.5%
Үндсэн цалин	272,400,000.00	251,594,643.40	(20,805,356.60)	92.4%
Гэрээт ажлын цалин	26,400,000.00	26,400,000.00	-	100.0%
Хоол унааны хөнгөлөлт бусад нэмэгдэл	72,738,000.00	43,385,915.00	(29,352,085.00)	59.6%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,869,180.00	36,986,339.01	(3,882,840.99)	90.5%
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	33,438,420.00	30,698,044.93	(2,740,375.07)	91.8%
Тэтгэврийн даатгал	26,007,660.00	23,951,475.40	(2,056,184.60)	92.1%
Тэтгэмжийн даатгал	2,972,304.00	2,737,311.14	(234,992.86)	92.1%
ҮОМШ өвчний даатгал	3,715,380.00	3,396,678.97	(318,701.03)	91.4%
Ажилгүйдлын даатгал	743,076.00	612,579.42	(130,496.58)	82.4%
Байгууллага төлөх ЭМД-ын хураамж	7,430,760.00	6,288,294.08	(1,142,465.92)	84.6%
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	166,671,500.00	166,598,557.96	(72,942.04)	100.0%
Байрны түрээс	70,305,000.00	70,285,000.00	(20,000.00)	100.0%
Бичиг хэргийн материал	9,049,000.00	8,955,068.70	(93,931.30)	99.0%
Тээвэр, шатахууны зардал	7,978,800.00	7,854,000.00	(124,800.00)	98.4%
Шуудан холбооны зардал	6,504,000.00	5,909,111.24	(594,888.76)	90.9%
Дотоод томилолтын зардал	6,900,200.00	6,713,944.00	(186,256.00)	97.3%
Гадаад томилолтын зардал	-	326,485.96	326,485.96	-
Ном , хэвлэлийн зардал	1,680,000.00	1,666,600.00	(13,400.00)	99.2%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,772,500.00	12,597,062.60	8,824,562.60	333.9%
Тавилга	10,790,000.00	10,161,740.00	(628,260.00)	94.2%
Жижиг эд хогшил худалдан авах зардал	2,412,000.00	2,361,289.00	(50,711.00)	97.9%
Төлбөр, хураамж, жижиг татварууд	8,650,000.00	1,867,307.90	(6,782,692.10)	21.6%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр хураамж	11,000,000.00	10,968,277.60	(31,722.40)	99.7%
Банкны үйлчилгээний хураамж	-	43,000.00	43,000.00	-
Мэдээлэл технологийн зардал	15,800,000.00	15,131,060.00	(668,940.00)	95.8%
Урсгал засварын зардал	7,116,000.00	6,970,670.00	(145,330.00)	98.0%
Аудит баталгаажуулах, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,000,000.00	(500,000.00)	80.0%
Эд хөрөнгийн даатгал	2,000,000.00	2,612,790.96	612,790.96	130.6%

тээврийн хэрэгслэлийн даатгал	170,000.00	135,150.00	(34,850.00)	79.5%
Тээврийн хэрэгслэлийн оношлогоо	44,000.00	40,000.00	(4,000.00)	90.9%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	33,000,000.00	33,964,296.00	964,296.00	102.9%
VI. ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	612,078,680.00	578,791,243.42	(33,287,436.58)	94.6%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	612,078,680.00	572,557,743.42	(39,520,936.58)	93.5%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,233,500.00	6,233,500.00	-
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	144,611,568.81	144,611,568.81	-
Байгууллагын тоо	1.00	1.00	-	100.0%
Ажиллагсад бүгд	23.00	22.00	(1.00)	95.7%
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	21.00	20.00	(1.00)	95.2%
Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.0%
Гэрээт ажилтан	-	-	-	-